



Г. Хүнгээр

Захирчжийн хөргүүлэгч
хамгаалж ажлыг дэвшиж дүүрэг

ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

ЧР дүн төслийн
засаглал

2022 оны 03 сарын 01 өдөр

Дугаар 1188

Эрдэнэт

Одуген 2022.03.01

Г “Эх, хүүхдэд ээлтэй өрхийн эрүүл мэндийн төв”
шалгаруулах аян зохион байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.5, 11.1.8 дэх хэсэг, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дүгээр сарын 02-ны өдрийн ээлжит VI хуралдааны 06/04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн
ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хэмжээнд “Эх, хүүхдэд ээлтэй өрхийн эрүүл мэндийн төв” шалгзуулах аян зохион байгуулах удирдамжийг нэгдүгээр, аянд шаардагдах төсвийн тооцоог хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Зардалд шаардагдах 5,000,000 (таван сая) төгрөгийг төсөл хөтөлбөрийн зардлын (Боловсрол, эрүүл мэнд, соёл, спортын олон нийтийн арга хэмжээг жилийн турш зохион байгуулах) зардлаас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү төрийн сангийн хэлтэс (Н.Бямбацэцэг)-т зөвшөөрсүгэй.

3. Батлагдсан хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулан, үр дүнг тайлagnаж ажиллахыг Эрүүл мэндийн газар (Д.Сүхээ), захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс (А.Бумансор)-т тус тус үүрэг болгосугай.



Аймгийн Засаг даргын 2022 оны
02 дугаар сарын 01-ын өдрийн
A/88-дугаар захирамжийн I хавсралт

**“ЭХ, ХҮҮХДЭД ЭЭЛТЭЙ ӨРХИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВ“
ШАЛГАРУУЛАХ АЯНЫ УДИРДАМЖ**

Нэг. Зорилго

Монгол улсын Тогтвортой хөгжлийн зорилт, Засгийн газрын 2020 -2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.1.1.3 дахь заалт, ЭМС-ын 2021 оны 760 дугаар тушаалаар батлагдсан “Эх хүүхэд нөхөн үржихүйн эрүүл мэнд” арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах хүрээнд эх хүүхдэд ээлтэй цогц орчинд тусlamж үйлчилгээ үзүүлэх нөхцлийг бүрдүүлэн эрсдэлт хүчин зүйл болон сэргийлж болох өвчлөл эндэгдлийг бууруулах

Хоёр. Зорилт

1. Эх, хүүхэд, нөхөн үржихүйн тусlamж үйлчилгээнд хэрэгжиж байгаа эрх зүйн баримт бичгийн хэрэгжилтийг нэмэгдүүлэх

2. Эх, хүүхдэд ээлтэй цогц, аюулгүй орчинг бүрдүүлэн тусlamж үйлчилгээг нэг цэгээс авах боломжийг бүрдүүлэх

3. Эх, хүүхдэд эрүүл мэндийн тусlamж үйлчилгээ үзүүлэх өрхийн эмч, эмнэлгийн мэргэжилтний ур чадварыг нэмэгдүүлэх

4. Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсрол олгох сургалт, сурталчилгааг нэмэгдүүлж, сэргийлж болох өвчлөл, эндэгдлийг бууруулах

Гурав. Хамрах хүрээ

Өрхийн эрүүл мэндийн төвүүд

Дөрөв. Болзлын хугацаа

2022 оны 02 дугаар сарын 25-наас 2022 оны 05 дугаар сарын 25-ны өдөр хүртэл нийт 3 сарын хугацаанд үргэлжилнэ. Аянг дүгнэж, 06 дугаар сарын 1 буюу “Эх үрсийн баярын өдөр” шагналыг гардуулна.

Тав. Хийх үйл ажиллагааны чиглэл

1. Төрөх насны эмэгтэйчүүд, жирэмсний нэрийн хяналтыг тогтмолжуулан нөхөн үржихүйн нэг цэгийн үйлчилгээг үзүүлэх

2. Жирэмсний эрт үеийн хяналт болон хяналтын хугацаан дахь 6-8 удаагийн үзлэг, эхээс урагт дамжих гурвалсан халдвартын оношилгоог чанаржуулах

3. Эх баригч, эх барих эмэгтэйчүүдийн эмч, хүүхдийн эмчийг орон тоогоор дагнан ажиллуулж, НҮЭМ, жирэмсэн, хүүхдийн тусlamж үйлчилгээний чанар хүртээмж, үр дүн, хэрэгцээг үнэлэх

4. Жирэмсэн эх, хүүхдийн үзлэг, хяналт, дархлаажуулалт болон өвчтэй хүүхдэд ХӨЦМ-ийн дагуу тусlamж үйлчилгээг ээлтэй орчинд нэг цэгээс үзүүлэх боломжийг бүрдүүлэн хүүхэд өлгийдэх, хөхүүлэх, хувцаслах, шингэн сэлбэх хэсгийг тохижуулах, тусlamж үйлчилгээ авах явцад эх хүүхдийн аюулгүй байдлыг хангах, Ковид-19 зэрэг бусад халдварт өвчинд өртөх

эрсдлийг бууруулах зэрэг зохицуулалт, зохион байгуулалтын өөрчлөлт шинэчлэлт, хөрөнгө оруулалт хийх

5. Эцэг эх, олон нийтэд 5 хүртэл насны хүүхдийн асран хамгаалахуйн эерэг дадал хандлага олгоход чиглэсэн сургалт сурталчилгааг эрчимжүүлэн сэргийлж болох эндэгдлийг бууруулах

6.Өрхийн эмч, эх баригч, эмнэлгийн мэргэжилтний жирэмсэн, хүүхдийн хооллолт, асран хамгаалахуйн эерэг дадал олгох чадварыг нэмэгдүүлэх

Зургаа. Аяныг дүгнэх, шалгаруулах

1.Өрхийн эрүүл мэндийн төвүүд хийсэн ажлын баримтжуулсан тайлан, шалгуур үзүүлэлтийн дагуу тоон үзүүлэлт, хүрсэн үр дүнг Эрүүл мэндийн газарт 2022 оны 05 сарын 28-ны дотор бичгээр ирүүлнэ.

2.Ажлын хэсэг ирүүлсэн материалыг судлан эхний шатанд шалгарсан байгууллагуудад газар дээр нь үзэж танилцан, шалгаруулалтыг 2022 оны 05 сарын 30-ны дотор явуулна.

Долоо. Шагнал урамшуулал:

1.“Эх, хүүхдэд ээлтэй өрхийн эрүүл мэндийн төв” -1-р байр-1 өргөмжлөл, мөнгөн шагнал

2. “Эх, хүүхдэд ээлтэй өрхийн эрүүл мэндийн төв”- 2-р байр -1 өргөмжлөл, мөнгөн шагнал

3.“Эх хүүхдэд ээлтэй өрхийн эрүүл мэндийн төв”-3-р байр-1 өргөмжлөл, мөнгөн шагнал

Найм. Шалгуур үзүүлэлт

Шалгуур үзүүлэлт бүрийг 0-5 оноогоор дүгнэнэ

№	Шалгуур үзүүлэлт	Тоон үзүүлэлт /хүрсэн үр дүн	Оноо
1.	Төрөх насны эмэгтэйчүүд, жирэмсний нэрийн хяналтыг тогтмолжсон байх, нөхөн үржихүйн нэг цэгийн үйлчилгээний үзүүлэлтүүд		
2.	Жирэмсний эрт үеийн хяналт, хяналтын хугацаанд 6-8 удаа үзүүлсэн хувь		
3.	НҮЭМ, жирэмсний тусламж үйлчилгээний чанар хүртээмж, үр дүн, хэрэгцээнд хийсэн үнэлгээний үзүүлэлт		
4.	Орон тоогоор ажиллаж байгаа эх баригч, эх барих эмэгтэйчүүд, хүүхдийн эмчийн тоо		
5.	Жирэмсэн эх, хүүхдэд ээлтэй цогц, аюулгүй орчинг бүрдүүлэн тусламж үйлчилгээг нэг цэгээс авах боломжийг бүрдүүлэхэд хөрөнгө оруулалт хийсэн эсэх		
.7	Эрүүл хүүхдийн үзлэгийн өрөөний тохижилт, багаж тоног төхөөрөмжийн хангалтын хувь		
8.	5 хүртэл насны хүүхдийн товтолын дархлаажуулалтад хамрагдсан хувь		
9.	Эх хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсрол олгох, сэргийлж болох эндэгдлийг бууруулах талаар хийсэн сургалт, сурталчилгааны тоо		

10	Жирэмсэн, хүүхдийн хооллолт, асран хамгаалахуйн зөрөг дадал олгох сургалтанд хамрагдан чадавхжуулсан эмч, эх баригч, эмнэлгийн мэргэжилтний тоо		
----	-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------	--	--

ОО



Аймгийн Засаг даргын 2022 оны
03 дугаар сарын 01-ын өдрийн

A/88..дугаар захирамжийн II хавсралт

ШААРДАГДАХ ТӨСВИЙН ЗАДАРГАА

№	Нэр төрөл	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	“Эх, хүүхдэд ээлтэй өрхийн эрүүл мэндийн төв” 1-р байр	1	2,000,000	2,000,000
2	“Эх, хүүхдэд ээлтэй өрхийн эрүүл мэндийн төв” 2-р байр	1	1,500,000	1,500,000
4	“Эх, хүүхдэд ээлтэй өрхийн эрүүл мэндийн төв” 3-р байр	1	1,000,000	1,000,000
5	Бусад үйл ажиллагааны зардал	1	500,000	500,000
6	Нийт дүн			5,000,000

OO